

“Зоосбанк” ХК-ийн нэмж гаргах  
хувьцааг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.2 дахь заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.7 дахь заалт, “Зоосбанк” ХК-ийн хувь нийлүүлэгчдийн 2008 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн ээлжит хурлын 03, 04 тоот тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.“Зоосбанк” ХК-ийн хувь нийлүүлэгчдийн 2008 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн ээлжит хурлын 03 тоот тогтоолыг үндэслэн нэг бүр нь 1000 /нэг мянга/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1 666 703 /нэг сая зургаан зуун жаран зургаан мянга долоон зуун гурав/ ширхэг энгийн хувьцааг хаалттай хэлбэрээр гаргахаар шийдвэрлэснийг үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/-г, хөрөнгийн биржийн бүртгэлд бүртгэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Р.Содхүү/-д, үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн бүртгэлд бүртгэхийг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

2.Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 15 дугаар тогтоолын 3-т заасан 1 999 974 ширхэг энгийн хувьцаа болон шинээр гаргаж буй 1 666 703 ширхэг энгийн хувьцаа, нийт 3 666 677 ширхэг энгийн хувьцааг зөвхөн стратегийн хөрөнгө оруулагч болох Европын сэргээн босголт хөгжлийн банкинд Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2008 оны 5 дугаар сарын 05-ны өдрийн 21 тоот тогтоолд заасан үнээр худалдахыг “Зоосбанк” ХК /Ш.Чуданжий/-д зөвшөөрсүгэй.

3.Нийт 3 666 677 ширхэг энгийн хувьцааг стратегийн хөрөнгө оруулагч болох Европын сэргээн босголт хөгжлийн банкинд арилжаалахыг “Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д, үнэт цаасны анхдагч арилжааны шимтгэлийг “Монголын хөрөнгийн бирж” ХК, “Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв”-д зохих журмын дагуу төлж, үнэт цаасны арилжааны тайланг хуульд заасан хугацаанд Хороонд ирүүлж, хувьцаа эзэмшигчдийн эрхийг ханган, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг “Зоосбанк” ХК /Ш.Чуданжий/-д тус тус үүрэг болгосугай.

4.“Зоосбанк” ХК-ийн 1 000 000 /нэг сая/ ширхэг давуу эрхийн хувьцааг 2 000 000 /хоёр сая/ ширхэг энгийн хувьцаанд хөрвүүлэхийг “Зоосбанк” ХК /Ш.Чуданжий/-д зөвшөөрсүгэй.

5.Энэхүү тогтоолын хавсралтад заасан давуу эрхийн хувьцааг эзэмшиж буй иргэн, хуулийн этгээдийн энгийн хувьцаанд хөрвөсөн хувьцааны өмчлөх эрхийг баталгаажуулан бүртгэлд өөрчлөлт оруулж бүртгэхийг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д үүрэг болгосугай.

6.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/-т даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:  
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ